



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: СЭА-2026/192/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: <a href="http://www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a>	Дарга, тэргүүлэх аудитор: Б.Батмөнх Утас: 7036-3040 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn
Сүхбаатар сум 2026 он	Ахлах аудитор: Ц.Отгонбаяр Утас: 7036-3036 Цахим хаяг: Otgonbayarts@audit.gov.mn
	Аудитор: Ц.Уртнасан Утас: 7036-2442 Цахим хаяг: urtaa6969@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЕРӨӨ СУМЫН  
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН  
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ  
Л.БОЛОРТУЯА ТАНАА

2026.02.25 № СМН-2026/192/НАСМ-ОУЗ,  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Ерөө сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Үүнд:

- Илүү цаг ажилласан үндэслэл, гүйцэтгэсэн ажил, цагийн тооцоогүйгээр нягтлан бодогч Р.Дариймаад 132 цагийн илүү цагийн нэмэгдэл тооцож **2,326.1** мянган төгрөгийг олгосон,
- Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлэлгүй худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй, шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн дутуу буюу хугацаа хоцроож мэдээлсэн зөрчлийг давтан гаргасан,
- Төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас **322.2** мянган төгрөгийн НДШ-ийн авлага үүсгэсэн байна.
- Батлагдсан төсвийн **1,516.4** мянган төгрөгийг зориулалт бусаар зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй

- Төсвийн хөрөнгөөр **20,599.0** мянган төгрөгийн барилгын засварын материал худалдан авч хөрөнгө нөөцөлсөн
- Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтыг үндэслэн **26,771.1** мянган төгрөгийн ажил гүйлгээг бүртгэж тайлагнасан

Аудитаар илэрсэн дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.5, Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 44 дүгээр зүйлийн 44.3, 44.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.5 дахь заалтууд болон Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 3 дугаар зүйлийн 3.1, 2024 оны “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоолын хавсралтын 1, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” -д заасантай тус тус нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тус сургууль нь Боловсролын ерөнхий газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/355 дугаар тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 1 дүгээр түвшинд үнэлэгдэж урамшуулалд 50,328.2 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

#### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тус байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй өөрөөр хэлбэл боловсролын салбарын онцлогт тохирохгүй байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын ерөнхий боловсролын сургуулийн тайлант онд 5 зорилтын хүрээнд 60 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж жилийн эцсийн гүйцэтгэлийн тайлангийн үнэлгээгээр 93.0 хувийн биелэлттэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

---

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БАТМӨНХ

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	/төгрөгөөр/	
		1. Эхний үлдэгдэл	2. Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	723,085,506.3	691,989,563.2
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	477,559,853.4	431,435,819.8
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	477,559,853.4	431,435,819.8
31210	Төгрөг	477,559,853.4	431,435,819.8
31211	Төрийн сангийн харилцах	477,559,853.4	431,435,819.8
33	АВЛАГА	-	322,200.2
33500	Бусад авлага	-	322,200.2
33510	Байгууллагаас авах авлага	-	322,200.2
35	БАРАА МАТЕРИАЛ	245,525,652.9	260,231,543.2
35100	Түүхий эд материал	23,532,826.3	24,720,326.3
35110	Тусгай зориулалттай материал	23,532,826.3	24,720,326.3
35400	Хангамжийн материал	221,992,826.7	235,511,217.0
35410	Бичиг хэргийн материал	-	450,000.0
35420	Аж ахуйн материал	75,877,128.3	76,807,128.3
35430	Сэлбэг хэрэгсэл	750,000.0	750,000.0
35450	Барилгын засварын материал	20,599,000.0	20,599,000.0
35460	Хүнсний материал	188,360.0	-
35470	Бусад хангамжийн материал	124,578,338.3	136,905,088.6
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	12,706,174,927.5	12,599,118,014.3
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12,706,174,927.5	12,599,118,014.3
39200	Биет хөрөнгө	12,624,000,760.4	12,516,943,847.3
39201	Барилга, байгууламж, орон сууц	12,316,891,769.0	12,526,891,769.0
39202	Хуримтлагдсан элэгдэл	(616,932,459.1)	(769,976,890.6)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	18,610,500.0	18,610,500.0
39204	Хуримтлагдсан элэгдэл	(18,610,500.0)	(18,610,500.0)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	1,001,456,665.8	996,861,639.8
39206	Хуримтлагдсан элэгдэл	(259,096,025.7)	(421,358,936.9)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	166,824,751.7	186,498,051.7
39208	Хуримтлагдсан элэгдэл	(88,264,646.4)	(102,414,667.1)
39209	Зам, гүүрийн байгууламж	16,887,852.0	16,887,852.0
39210	Хуримтлагдсан элэгдэл	(7,895,800.0)	(7,895,800.0)
39214	Бусад үндсэн хөрөнгө	75,289,854.0	75,289,854.0
39215	Хуримтлагдсан элэгдэл	(28,992,149.4)	(34,915,129.5)
39217	Ном	47,830,948.5	51,076,104.9
39300	Биет бус хөрөнгө	82,174,167.0	82,174,167.0
39301	Програм хангамж	8,803,000.0	8,803,000.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	(7,638,833.0)	(7,638,833.0)
39303	Бусад биет бус хөрөнгө	81,010,000.0	81,010,000.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	13,429,260,433.7	13,291,107,577.5
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	46,040,042.0	28,256,042.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	46,040,042.0	28,256,042.0
41300	Өглөг	46,040,042.0	28,256,042.0
41360	Бусад өглөг	46,040,042.0	28,256,042.0
41361	Байгууллагад төлөх өглөг	46,040,042.0	28,256,042.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	13,383,220,391.7	13,262,851,535.5
51	Засгийн газрын хувь оролцоо	13,383,220,391.7	13,262,851,535.5
51100	Засгийн газрын оруулсан капитал	570,012,254.7	570,012,254.7
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	570,012,254.7	570,012,254.7
51200	Хуримтлагдсан үр дүн	12,605,621,379.7	12,485,252,523.5
51210	Өмнөх үеийн үр дүн	12,138,591,319.3	12,605,621,379.7
51220	Тайлант үеийн үр дүн	467,030,060.4	(120,368,856.2)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	207,586,757.4	207,586,757.4

6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	13,429,260,433.7	13,291,107,577.5
---	----------------------------------------------	------------------	------------------

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	/төгрөгөөр/	
		1. Өмнөх он	2. Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	3,615,657,715.89	3,800,434,745.52
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	400,565,649.70	3,251,616,986.66
120	Нийтлэг татварын бус орлого	400,565,649.70	221,165,086.66
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	12,395,000.00	2,300,980.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,945,000.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,450,000.00	2,300,980.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	369,518,769.20	215,345,156.36
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	18,651,880.50	3,518,950.30
122	Тусламжийн орлого	-	3,030,451,900.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	3,030,451,900.00
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	3,030,451,900.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого\	-	3,030,451,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,670,801,400.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,670,801,400.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,670,801,400.00	-
132001	Орон нутгийн төсвөөс	544,290,666.19	548,817,759
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,148,627,655.39	3,371,985,842.87
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,604,336,989.28	3,371,985,842.87
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,056,302,471.72	3,060,829,564.39
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,830,468,235.04	2,349,788,847.61
210101	Үндсэн цалин	1,195,064,640.09	1,457,792,043.79
210102	Нэмэгдэл	561,286,607.95	696,576,142.82
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	66,095,000.00
210104	Урамшуулал	74,116,987.00	129,325,661.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	224,366,091.65	292,307,556.60
210201	Тэтгэврийн даатгалын зардал	154,333,943.39	200,959,676.88
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	18,031,854.81	23,421,545.19
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	9,185,041.28	12,167,822.26

210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	8,563,071.81	11,151,663.47
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	34,252,180.36	44,606,848.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	531,698,066.19	538,919,758.86
210301	Гэрэл, цахилгаан	64,515,384.19	83,475,106.86
210302	Түлш, халаалт	452,419,000.00	447,786,672.00
210303	Цэвэр, бохир ус	14,763,682.00	7,657,980.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,592,600.00	9,898,000.00
210604	Урсгал засвар	12,592,600.00	9,898,000.00
2105	Нормативт зардал	57,373,751.00	73,029,092.00
210502	Хоол, хүнс	57,373,751.00	73,029,092.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,674,623.30	37,692,909.66
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	300,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	19,674,623.30	37,392,909.66
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	380,129,104.54	431,594,757.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	86,820,664.70	45,382,588.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	19,912,850.00	22,537,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	273,395,589.84	363,674,369.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	92,325,183.75	187,572,679.50
2132	Бусад урсгал шилжүүлэг	92,325,183.75	187,572,679.50
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	92,325,183.75	137,244,479.50
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	50,328,200.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	467,030,060.42	(120,368,856.21)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	467,030,060.42	(120,368,856.21)

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	/төгрөгөөр/	
		1. Өмнөх он	2. Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	3,227,487,066.20	3,581,570,638.86
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	12,395,000.00	3,581,570,638.86
120	Нийтлэг татварын бус орлого	12,395,000.00	2,300,980.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	12,395,000.00	2,300,980.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,945,000.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,450,000.00	2,300,980.00
122	Тусламжийн орлого	-	3,030,451,900.00

1221	Хандив тусламж /дотоод/	-	3,030,451,900.00
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	3,030,451,900.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого\	-	3,030,451,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,670,801,400.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,670,801,400.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,670,801,400.00	
132001	Орон нутгийн төсвөөс	544,290,666.20	548,817,758.86
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,870,277,785.60	3,627,694,672.47
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,325,987,119.41	3,037,604,613.61
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,782,592,861.85	3,586,422,372.47
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,831,248,832.31	2,349,793,593.61
210101	Үндсэн цалин	1,195,268,737.36	1,457,792,043.79
210102	Нэмэгдэл	561,863,107.95	696,580,888.82
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	66,095,000.00
210104	Урамшуулал	74,116,987.00	129,325,661.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	224,366,091.65	292,625,010.84
210201	Тэтгэврийн даатгалын зардал	154,333,943.39	201,277,131.12
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	18,031,854.81	23,421,545.19
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	9,185,041.28	12,167,822.26
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	8,563,071.81	11,151,663.47
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	34,252,180.36	44,606,848.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	531,698,066.19	538,919,758.86
210301	Гэрэл, цахилгаан	64,515,384.19	83,475,106.86
210302	Түлш, халаалт	452,419,000.00	447,786,672.00
210303	Цэвэр, бохир ус	14,763,682.00	7,657,980.00
2105	Нормативт зардал	56,194,579.00	72,840,732.00
210502	Хоол, хүнс	56,194,579.00	72,840,732.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,592,600.00	9,898,000.00
210604	Урсгал засвар	12,592,600.00	9,898,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	28,658,763.70	37,692,909.66
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	300,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	28,658,763.70	37,392,909.66
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	97,833,929.00	97,079,688.00

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	76,745,279.00	80,133,188.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	21,088,650.00	16,946,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	87,684,923.75	187,572,679.50
2132	Бусад урсгал шилжүүлэг	87,684,923.75	187,572,679.50
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	87,684,923.75	137,244,479.50
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	50,328,200.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	357,209,280.59	(4,851,733.61)
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	68,929,758.00	41,272,300.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	68,929,758.00	41,272,300.00
2200	Дотоод эх үүсвэрээр	68,929,758.00	41,272,300.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	68,929,758.00	41,272,300.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(68,929,758.00)	(41,272,300.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	288,279,522.59	(46,124,033.61)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	189,280,330.79	477,559,853.38
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	477,559,853.38	431,435,819.77
99	Хамаарахгүй	-	-

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Дансны нэр, төрөл	<i>/төгрөгөөр/</i>			
	1.1 Засгийн газрын оруулсан капитал	1.2 Дахин үнэлгээний нөөц	1.3 Хуримтлагдсан үр дүн	1.4 Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	570,012,254.67	207,586,757.37	12,138,591,319.28	12,916,190,331.32
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	570,012,254.67	207,586,757.37	12,138,591,319.28	12,916,190,331.32
Тайлант үеийн үр дүн	-	-	467,030,060.42	467,030,060.42
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	570,012,254.67	207,586,757.37	12,605,621,379.70	13,383,220,391.74
2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	570,012,254.67	207,586,757.37	12,605,621,379.70	13,383,220,391.74
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	570,012,254.67	207,586,757.37	12,605,621,379.70	13,383,220,391.74
Тайлант үеийн үр дүн	-	-	(120,368,856.21)	(120,368,856.21)
2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	570,012,254.67	207,586,757.37	12,485,252,523.49	13,262,851,535.53

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан Улсын төсөв

/төгрөгөөр/

Дан-ны код	Дансны нэр, төрөл	1. Төлөвлөгөө	2. Гүйцэтгэл	12. Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	3,618,881,158.86	3,581,570,638.86	37,310,520.00	99.0
12	Татварын бус орлого	3,618,881,158.86	3,581,570,638.86	37,310,520.00	99.0
120	Нийтлэг татварын бус орлого	2,301,100.00	2,300,980.00	120.00	100.0
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	2,301,100.00	2,300,980.00	120.00	100.0
122	Тусламжийн орлого	3,067,762,300.00	3,030,451,900.00	37,310,400.00	98.8
122005	Төсвөөс санхүүжих	3,067,762,300.00	3,030,451,900.00	37,310,400.00	98.8
132001	Орон нутгийн төсвөөс	548,817,758.86	548,817,758.86	-	100.0
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,091,176,158.86	3,627,694,672.47	463,481,486.39	88.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,091,176,158.86	3,627,694,672.47	463,481,486.39	88.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,893,353,758.86	3,440,121,992.97	453,231,765.89	88.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,731,794,900.00	2,349,793,593.61	382,001,306.39	86.0
210101	Үндсэн цалин	1,658,260,600.00	1,457,792,043.79	200,468,556.21	87.9
210102	Нэмэгдэл	974,504,000.00	696,580,888.82	277,923,111.18	71.5
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	66,095,000.00	(66,095,000.00)	
210104	Урамшуулал	99,030,300.00	129,325,661.00	(30,295,361.00)	130.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	341,632,800.00	292,625,010.84	49,007,789.16	85.7
210201	Тэтгэврийн даатгал	232,310,400.00	201,277,131.12	31,033,268.88	86.6
210202	Тэтгэмжийн даатгал	27,330,600.00	23,421,545.19	3,909,054.81	85.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,665,300.00	12,167,822.26	1,497,477.74	89.0
210204	Ажилгүйдлийн даатгал	13,665,300.00	11,151,663.47	2,513,636.53	81.6
210205	Эрүүл мэндийн даатгал	54,661,200.00	44,606,848.80	10,054,351.20	81.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	538,919,758.86	538,919,758.86	-	100.0
210301	Гэрэл, цахилгаан	83,475,106.86	83,475,106.86	-	100.0
210302	Түлш, халаалт	447,786,672.00	447,786,672.00	-	100.0
210303	Цэвэр, бохир ус	7,657,980.00	7,657,980.00	-	100.0
2105	Нормативт зардал	81,980,800.00	72,840,732.00	9,140,068.00	88.9
210502	Хоол, хүнс	81,980,800.00	72,840,732.00	9,140,068.00	88.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,898,000.00	9,898,000.00	-	100.0

210604	Урсгал засвар	9,898,000.00	9,898,000.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	47,640,500.00	37,692,909.66	9,947,590.34	79.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	629,500.00	300,000.00	329,500.00	47.7
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	47,011,000.00	37,392,909.66	9,618,090.34	79.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	141,487,000.00	138,351,988.00	3,135,012.00	97.8
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	124,540,500.00	121,405,488.00	3,135,012.00	97.5
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	16,946,500.00	16,946,500.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	197,822,400.00	187,572,679.50	10,249,720.50	94.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	197,822,400.00	187,572,679.50	10,249,720.50	94.8
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	147,494,200.00	137,244,479.50	10,249,720.50	93.1
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	50,328,200.00	50,328,200.00	-	100.0
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	(472,295,000.00)	(46,124,033.61)	(426,170,966.39)	9.8
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	472,295,000.00	46,124,033.61	426,170,966.39	9.8
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	472,295,000.00	46,124,033.61	426,170,966.39	9.8
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	477,559,853.38	(477,559,853.38)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	431,435,819.77	(431,435,819.77)	

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой **481,957.3** мянган төгрөгийн дараах алдааг залрууллаа. Үүнд:

- Санхүүгийн байдлын тайлангийн бараа материалын эхний үлдэгдэл нь эд хариуцагчийн бараа материалын тайлангийн эхний үлдэгдлээс 68,190.4 мянган төгрөгөөр илүү тайлагнагдсан,
- Санхүүгийн байдлын тайлангийн үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл нь эд хариуцагчийн үндсэн хөрөнгийн тайлангийн эхний үлдэгдлээс 81,846.8 мянган төгрөгөөр илүү тайлагнагдсан,
- Санхүүгийн байдлын тайлангийн үндсэн хөрөнгийн элэгдлийн эхний үлдэгдэл нь үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийг тайлангийн эхний үлдэгдлээс 79,928.3 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн,
- Тайлант онд нэмж байгуулсан үндсэн хөрөнгийн 243,467.5 мянган төгрөгийн элэгдлийг санхүүгийн байдлын тайланд дутуу тайлагнасан,
- Үр дүнгийн тайланд хичээл үйлдвэрлэлийн зардлыг 5,693.3 мянган төгрөгөөр, үдийн цайны зардлыг 2,831.0 мянган төгрөгөөр тус тус илүү тайлагнасан.

Дээрх алдаанууд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*”, УСНББОУС-1 “*Санхүүгийн тайлангийн толилуулга агуулга*”-ийн 27-д “*Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой...*”, УСНББОУС 17-ын 59-д “*Үндсэн хөрөнгийн тухайн зүйлийн нийт өртөгтэй харьцуулахад мэдэгдэхүйц өртөг бүхий хэсэг бүрийг тусад нь элэгдүүлнэ*” гэсэн заалтууд болон “*Үнэлгээ ба хуваарилалт*” батламж мэдэгдлийг тус тус хангаагүй байна.

Аудитаар нийт **426,167.2** мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс 3,788.7 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 49,208.7 мянган төгрөгийн 4 зөрчилд албан шаардлага хүргүүлэн, 373,169.8 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж өгөв.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 52,997.4 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын 31,486.3 мянган төгрөгийн түвшнээс 21,511.1 мянган төгрөгөөр их тул **Хязгаарлалттай** дүгнэлт өглөө.

### **3.1 Төлбөрийн акт**

**3.1.1** Илүү цаг ажилласан үндэслэл, гүйцэтгэсэн ажлын тайлангүй, цагийн тооцоогүйгээр нягтлан бодогч Р.Дариймаад 132 цагийн илүү цагийн нэмэгдэл тооцож 2,326.1 мянган төгрөг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “*Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дүгээр зүйлийн 20.2.5 дахь “*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*”, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 3 дугаар зүйлийн 3.1 дэх “*Төрийн албан хаагч энэ журмын хавсралтаар баталсан “Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас”-ны дагуу илүү цагаар, ..... ажилласан үндэслэл, гүйцэтгэсэн ажлын гол агуулга, нэмэгдүүлсэн цалин хөлсний тооцоог нэгжийн даргаар хянуулж баталгаажуулсны үндсэн дээр байгууллагын дарга зөвшөөрөл олгосны дараа санхүүд хүргүүлнэ*”, 3.2: “*Нэмэгдэл хөлсийг төрийн албан хаагчийн илүү цагаар, .... ажилласны дараа сарын цалин хөлстэй хамт тооцож олгоно*” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Илүү олгосон нэмэгдэл цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

**3.1.2** Анхан шатны баримтын бүрдэлгүйгээр 1,462.6 мянган төгрөгийн түлш, шатахууныг зарцуулснаар тайлагнаж, бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь “*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*”, 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх “*хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх*” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**Шийдвэрлэсэн нь:** Анхан шатны баримтын бүрдэлгүйгээр буюу зарцуулалт нь тодорхойгүй шатахууныг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

### **3.2 Албан шаардлага**

**3.2.1.** Төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас 322.2 мянган төгрөгийн НДШ-ийн авлага үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “*Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “*Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх албан шаардлага хүргүүлэв.

**3.2.2.** Батлагдсан төсвийг зориулалт бусаар зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй дараах **1,516.4** мянган төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнд:

- Орон нутгийн төсвийн цэвэр бохир усны зардлын батлагдсан төсвөөс хог хаягдлын хураамжийн **396.4** мянган төгрөгийн үйлчилгээний төлбөр,
- Бараа үйлчилгээний зардлын батлагдсан төсвөөс **1,120.0** мянган төгрөгийн хичээлийн хэрэглэгдэхүүний үнийг шилжүүлсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*” гэж заасныг болон Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг тус тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, үнэн зөв тайлагнаж байх албан шаардлага хүргүүлэв.

**3.2.3.** Өмнөх оны төсвийн хөрөнгөөр **20,599.0** мянган төгрөгийн хашааны төмөр, шланк, паркетен шал зэргийг худалдан авсан боловч тайлант онд зарцуулалгүй барилгын засварын материалын дансанд үлдэгдлээр тайлагнан шаардлагагүй хөрөнгө нөөцөлсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “*Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “*Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно:*”, 15.1.6 дахь “*нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх;*” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа материалыг нөөцлөхгүй байх, төсвийг үр ашигтай, арвилан хэмнэлттэй зарцуулах албан шаардлага хүргүүлэв.

**3.2.4.** Тайлант онд нягтлан бодогч нь **26,771.1** мянган төгрөгийн санхүүгийн анхан шатны баримтыг хянаж шалгалгүйгээр хүчин төгөлдөр бус анхан шатны баримтыг үндэслэн ажил гүйлгээг бүртгэж тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 дахь “*Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна.*” 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх “*хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх;*” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хүчин төгөлдөр анхан шатны баримтыг үндэслэн ажил гүйлгээг бүртгэж тайлагнаж байх албан шаардлага хүргүүлэв.

### **3.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1.Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал:**

**1.1 Илрүүлэлт:** Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй тайлант оны эцэст ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа нийт 373,169.8 мянган төгрөгийн анхны үнэтэй хөрөнгийг дахин үнэлж бүртгээгүй, шинэчлэн тогтоох саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2 дахь “... элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох”, УСНББОУС-17 “Үндсэн хөрөнгө”-ийн 13 (б)-д “... байгууллага нь тухайн хөрөнгийг уг тайлангийн өдрөөр түүний одоогийн бодит үнэ цэнээр дахин үнэлэх хэрэгтэй ...” гэсэн заалтууд болон “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг тус тус хангаагүй байна.

**1.2 Шийдвэрлэсэн нь:** Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, ашиглаж байгаа үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох, актлах саналыг бэлтгэн, холбогдох газарт хүргүүлэн шийдвэрлүүлэх.

Дээрх зөвлөмжүүдийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5<sup>2</sup> дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг

---

<sup>2</sup> Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.



цагийн нэмэгдэл тооцож олгосон												
Анхан шатны баримтын бүрдэлгүйгээр түлш, шатахууныг зарцуулснаар тайлагнаж, бүртгэсэн	1	1,462.6	1	1,462.6								
Төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас авлага үүсгэсэн	1	322,2			1	322,2						
Батлагдсан төсвийг зориулалт бусаар зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй	1	1,516.4			1	1,516.4						
Өмнөх оны төсвийн хөрөнгөөр БМ-ыг тайлант онд зарцуулалгүй барилгын засварын материалын дансанд үлдэгдлээр тайлагнаж нөөцөлсөн	1	20,599.0			1	20,599.0						
Тайлант онд нягтлан бодогч нь санхүүгийн анхан шатны баримтыг хянаж шалгалгүйгээр хүчин төгөлдөр бус анхан шатны баримтыг үндэслэн ажил гүйлгээг бүртгэж тайлагнасан	1	26,771.1			1	26,771.1						
ҮХ дансанд бүртгэлтэй тайлант оны эцэст ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа анхны үнэтэй хөрөнгийг дахин үнэлж бүртгээгүй, шинэчлэн тогтоох саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлээгүй	1	373,169.8					1	373,169.8				
Өмнөх албан шаардлагыг хэрэгжүүлэлгүй худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, батлуулж, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулж ажиллаагүй	1								1	2		
<b>Дүн</b>	<b>8</b>	<b>426,167.2</b>	<b>2</b>	<b>3,788.7</b>	<b>4</b>	<b>49208.7</b>	<b>1</b>	<b>373,169.8</b>	<b>2</b>	<b>2</b>		

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчил								
		-				-		
<b>Нийт дүн</b>		-				-		

